



**ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 30 өдөр

Дугаар A/242

Зуунмод

Г Ариутгал, халдваргүйтгэлийн ажил Г
зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод сумын хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, хүн мал, амьтны халдварт өвчин дамжин тархах, орчны бохирдлыг бууруулах, мал амьтны халдварт гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 01-ний өдөр хүртэл 1 сарын хугацаанд сумын хэмжээнд зохион байгуулсугай.

2. Мал эмнэлгийн тасаг (Э.Долгормаа)-д ДААЛГАХ нь:

2.1. Мал, амьтны хашаа, хороо, хэвтэр, бууц, дэвсгэр, хөрзөн, төлийн пүнз, өвс тэжээлийн хашаа саравч, агуулах гэх мэт газруудын цэвэрлэгээг сайтар хийж, мэргэжлийн байгууллагатай хамтран халдваргүйтгэл, халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.

2.2. Хүн, малын гоц халдварт өвчин гарч болзошгүй бүс нутагт эрсдэлээс урьдчилан сэргийлж хөрсний бохирдол ихтэй нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайг нэг бүрчлэн тогтоож ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг шат дараатай зохион байгуулах.

2.3. Ариутгал, халдваргүйтгэлд ажиллаж байгаа эмч, мэргэжилтнүүдийн халдвар хамгааллын болон техникийн аюулгүй ажиллагааг хангаж ажиллах.

3. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж (Г.Цэндсүрэн)-д ДААЛГАХ нь:

3.1. Малыг халдварт болон гоц халдварт өвчин дахин сэргэж болзошгүй бүс нутгийн мал, амьтны хашаа, хороо, хэвтэр, бууц, дэвсгэр, хөрзөн, төлийн пүнз, өвс тэжээлийн хашаа саравчинд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг чанартай, үр дүнтэй зохион байгуулах.

3.2. Малчин мал бүхий иргэдийн ариун цэврээ сахих, эрүүл мэндээ хамгаалах, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, мал амьтны халдварт, гоц халдварт, зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, гарын авлага материал бэлтгэж тараах ажлыг зохион байгуулах.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Энхсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.САРАНГЭРЭЛ

